

ВАНСЭМБЭРҮҮ

Vansemberuu (Snow lotus)



Saussurea bogedaensis
Yu J.Wang & J.Chen, 2018

Ангилал зүй /Taxonomy

Хүрээ: / Phylum: Tracheophyta

Анги: / Class: Magnoliopsida

Бар: / Order: Asterales

Овог: Нийлмэл цэцэгтэн / Family: Asteraceae

Төрөл: Банздоо / Genus: *Saussurea*

Таних шинж

Олон наст өвслөг ургамал, 15-50 см өндөр. Иш ганц, цэх, 1.5-3 см голчтой. Сагсанд 15-30 баг цэцэгтэй. Ороолт хонхорхуу. Ороолт навчинцар үзүүр шөвгөрхүүгээс шовхдуу, дээд хэсгээрээ өтгөн үслэг. Цомцог бараан цагаан. 7-9 дүгээр сард цэцэглэж, үрлэнэ.

Description: Perennial herb 15-50 cm tall. Stem solitary, 1.5-3 cm diam. erect. Capitula number 15-30. Involucre campanulate. Phyllary subulate to acuminate, densely pubescent middle-upper part. Pappus color dirty white. Flowering and fruiting time June to September.

Ерөнхий тархалт Хятад (Зүүн Тэнгэр уулс), Монгол (Байтаг Богд Уулс)

General distribution: China (Eastern Tenger Mountains), Mongolia (Baitag Bogd Mountains)

Ургах орчин Өндөр уулын бүслүүрт хад, чулуурхаг асга, нуранги асга, чийглэг нугад далайн төвшнөөс дээш 2400-3300 м-д ургана.

Habitat: This species grows on high mountain rocky slopes, screes, boulders and river banks in the alpine belt at altitudes of 2400–3300 m a.s.l.


Статус Дэлхийн байгаль хамгаалах холбооны улаан данс – Устаж байгаа зүйл. (Baasanmunkh et al. 2020)

Энэ зүйл нь ГИДЦГ-ын “Б” хэсэгт байдаг.

Conservation status: IUCN Red list Globally and Regionally – **Critically Endangered** (EN). (Baasanmunkh et al. 2020)

This species found in the GGB SPA of Mongolia.

Reference: Baasanmunkh, S., Nyamgerel, N., Bayarmaa, G., Oyuntsetseg, B., Oyundelger, K. & Choi, H.J. (2020) A new record of critically endangered *Saussurea bogedaensis* (Asteraceae) from Dzungarian Gobi, Mongolia. *Phytokeys* 160: 109–121.



ТАХЬ ӨВС, ЦУЛБУУР ӨВС

Takhi uvs, Tsulbuur uvs
(Egeria Iris, Narrow leafed Iris)



Iris tenuifolia
Pall.

(Нарийн навчит цахилдаг), 1776

Ангилал зүй /Taxonomy

Хүрээ: / Phylum: Tracheophyta

Анги: / Class: Liliopsida

Баг: / Order: Asparagales

Овог: Цахилдаг / Family: Iridaceae

Төрөл: Цахилдаг / Genus: *Iris*

Таних шинж

Үндэслэг иш модожсон, хар бараан өнгөтэй. Навчис шугаман утсархуу, сааралдуу ногоон, туушдаа хуйлаастай, 20-60 см × 1.5-2 мм, гол судалгүй. Ишгүй цэцэг, түүний 3-4 бүрхэвч нь нягт дэгнүүлээс цухуйх төдий харагдана. Цэцэг цайвар нил ягаан, 4-7 см голчтой, гадаад салбан голдоо бараан судал

Description: Rhizomes dark brown, knobby, woody. Leaves grayish green, linear, twisted, 20-60 cm × 1.5-2 mm, midvein absent. Flowering stems not emerging above ground; spathes 3 or 4. Flowers pale violet, 4-7 cm in diam., outer segments white tinged yellow at center, veined darker. Capsule ovoid, 3.2-4.5 × 1.2-1.8 cm, apex shortly beaked. Flowering May to June, and fruiting July to August.

бүхий цайвар шардуу өргөн зурвастай. Хонгорцог өндгөрхүү, 3.2-4.5 × 1.2-1.8 см, үзүүр богино шонтоной. 5, 6 дугаар сард цэцэглэж, 7, 8 дугаар сард үрлэнэ.

Ерөнхий тархалт Афганистан, Казахстан, Монгол, Пакистан, Орос, Узбекистан

General distribution: Afghanistan, Kazakhstan, Mongolia, Pakistan, Russia, Uzbekistan.

Ургах орчин Элс, элс хайргат цөлийн хээр.

Малын тэжээлийн ургамал.

Habitat: Sandy and sandy-pebble desert steppe.

Forage for livestock.

УЛААНБУДАРГАНА

Ulaanbudargana



Таних шинж

Заримдаг сөөгөнцөр, 10-30 см өндөр, иш их салаархаг. Хөгшин мөчир хүрэн саарал, нэг наст мөчир улаавтар өнгөтэй. Дэвсмэл юмуу өндиймөл, өтгөн навчирхаг мөчиртэй. Навч бэлцгэр, тал бортогорхуу, шугаман, цэгэн булчирхайтай. Цэцэг ганц эсвэл сийрэг түрүүрхүү баг цэцэгтэй. Дэлбээ

Reaumuria songarica

(Pall.) Maxim. Pall.

(Зүүнгарын улаанбударгана), 1889

Ангилал зүй /Taxonomy

Хүрээ: / Phylum: Tracheophyta

Анги: / Class: Magnoliopsida

Баг: / Order: Caryophyllales

Овог: Сухай / Family: Tamaricaceae

Төрөл: Бударгана / Genus: *Reaumuria*

Description: Shrubs, small, 10-30 cm tall, much branched. Old branches gray-brown; branchlets reddish. Leaves often 4-6 clustered on shortened branches, grayish blue, fleshy, with dotlike salt-secreting glands, apex obtuse. Flowers solitary, axillary, apex acute. Petals white, tinged reddish, oblong. Capsule narrowly ellipsoid or fusiform, usually 3 or 4 seeded. Seeds oblong, 3-4 mm, black-brown hairy throughout, base attenuate, apex acuminate. Flowering May to July, and fruiting August to September.

цагаан, ягаан, хурц улаан, хэлтэс нь 5, доод хагастаа 2 дагалттай. Хонхорцог нарийн зууван эсвэл ээрүүлэрхүү, ихэвчлэн 3 юмуу 4 үртэй. Үр гонзгой, 3-4 мм, хүрэн хар үслэгтэй, суурь сунгуу, үзүүр хурц. 5-7 дугаар сард цэцэглэж, 8-9 дүгээр сард үрлэнэ.

Ерөнхий тархалт Хятад, Монгол

General distribution: China, Mongolia

Ургах орчин Цөл, тойрмын зах

Habitat: Desert, margins of lowlands

Жилийн аль ч улиралд тэмээ сайн иддэг.

Primary forage for camels, which graze it year-round.

ЦӨЛТҮРҮҮ

Tsulturuu



Таних шинж

Булцуурхуу үндэстэй, 15-40 см өндөр, эгц шулуун иштэй ургамал. Зөвхөн баг цэцэгтээ 2 хааяа 4 эсрэг суусан мөчиртэй, навчис нь өндгөрхүү мохоо шүдэрхэг, бариултай, 5-10 см урт, бүх бие нь урт сэгсгэр үстэй. Цоморлиг өргөн юүлүүрхүү, үзүүртээ жижиг өргөс бүхий маш богинохон

Phlomoides molucelloides
(Bunge) Salmaki
(Өргөн цоморлигт цөлтүрүү), 2012

Ангилал зүй /Taxonomy

Хүрээ: / Phylum: Tracheophyta

Анги: / Class: Magnoliopsida

Баг: / Order: Lamiales

Овог: Уруул цэцэгтэн / Family: Lamiaceae

Төрөл: Цөлтүрүү / Genus: *Phlomoides*

Description: Plant with tuberous root and straight stem 15-40 cm high, only in inflorescence with 2, rarely 4 opposite branches, with ovate obtuse-dentate leaves 5-10 cm long, plant villous throughout with long hairs. Calyx funnelform, with apical spines. Corolla lip yellow. Flowering June and fruiting July.

өргөн салбантай. Дэлбээ улбар шар өнгийн уруултай, тод шар. 6 дугаар сард цэцэглэж, 7 дугаар сард үрлэнэ.

Ерөнхий тархалт Хятад, Казахстан, Киргиз, Монгол, Орос, Тажикстан

General distribution: China, Kazakhstan, Kyrgyzstan, Mongolia, Russia, Tajikistan

Ургах орчин Цөлжүү хээрийн чулуурхаг хажуу, хад

Habitat: Desert steppe, stony slopes and rocks

Статус Дэлхийн байгаль хамгаалах холбооны улаан данс - Эмзэг

Зүүнгар, Ховдын тойргоор тархалттай ба амьдрах орчны хязгаарлагдмал нөхцлийн улмаас ховордож буй зүйл.

Conservation status: IUCN Red list Globally and Regionally - **Vulnerable** (VU)

This species is found only in Mongolia and only in the Dzungarian Gobi and in Khovd province. The population is decreasing due to this limited regional existence.

ПРЖЕВАЛСКИЙН ЧАРМАЙ, УЛААН ТҮЛЭЭ

Przewalskiin Charmai, Ulaan Tulee



*Gymnocarpus
przewalskii*

Bunge & Maxim

(Пржевальскийн чармай), 1880

Ангилал зүй / Taxonomy

Хүрээ: / Phylum: Tracheophyta

Анги: / Class: Magnoliopsida

Баг: / Order: Caryophyllales

Овог: Баширтан / Family: Caryophyllaceae

Төрөл: Чармай / Genus: *Gymnocarpus*

Таних шинж

Сөөгөнцөр 20-100 см өндөр, сууриасаа буталж салаалсан, нарийн сэрэвгэр мөчиртэй, ишний үе дээр шилмүүсэрхүү хатуу навчистай ба мөнгөлөг хальсан дагавар навчтай. Навчис шугамархуу, 5-20 × 1-1.5

Description: Shrublets 20-100 cm tall, with tender branches, bushy from base, with silvery scarious stipules in nodes and acicular rigid leaves. Leaves linear-subulate, 5-20 × 1-1.5 mm, apex acute, mucronate. Seeds brown, oblong. Flowering May to June and fruiting July to September.

мм, өргөслөг үзүүртэй. Үр хүрэн, гонзгой. 5, 6 дугаар сард цэцэглэж, 7-9 дүгээр сард үрлэнэ.

Ерөнхий тархалт Хятад, Монгол

General distribution: China, Mongolia

Ургах орчин Говь цөл, сайрын зах, хайрга чулуу

Habitat: Gobi Desert, rocky

Статус Дэлхийн байгаль хамгаалах холбооны улаан данс - Эмзэг. Жилийн аль ч улиралд тэмээ сайн иддэг.

Conservation status: IUCN Red list Globally and Regionally – **Vulnerable** (VU). Primary forage for camels, which graze it year round.

МАРЦСАГ ХОНХОТХАРГАНА

Martssag Khonkhotkhargana (Halodendron Salt Tree)



Таних шинж

Сөөг, 0.5-2 м өндөр, холтос улаандуу хүрэн, 2-6 см урт бахим өргөстэй, Цацаг 2-5 цэцэгтэй, цэцгийн шилбэ 1.5-3 см. Дэлбээ цайвар ягаан эсвэл ягаандуу улаан. Буурцаг түнтгэр, нүцгэн, тонгоруу өндгөрхүү, 1-3 см урт, 5-15 мм өргөн. Үр бөөрөрхүү. 7 дугаар сард цэцэглэж, 8 дугаар сард үрлэнэ.

*Caragana
halodendron*
(Pall.) Dum.Cours.
(Мөнгөлөг харгана) 1802

Ангилал зүй /Тахonomy

Хүрээ: / Phylum: Tracheophyta

Анги: / Class: Magnoliopsida

Баг: / Order: Fabales

Овог: Буурцагтан / Family: Fabaceae

Төрөл: Харгана / Genus: *Caragana*

Description: Shrubs, 0.5-2 m tall, bark reddish brown, strongly pungent, with spines 2-6 cm long. Racemes 2-5-flowered; peduncle 1.5-3 cm. Corolla pale purple or purplish red. Legume inflattened, glabrous, obovoid, 1-3 cm long, 5-15 mm wide. Seeds reniform. Flowering and fruiting time July to August.

Ерөнхий тархалт

Афганистан, Армени, Азербайджан, Хятад, Иран, Гүрж, Казахстан, Киргиз, Монгол, Пакистан, Орос, Туркменистан, Турк, Украин, Узбекистан.

General distribution: Afghanistan, Armenia, Azerbaijan, China, Iran, Georgia, Kazakhstan, Kyrgyzstan, Mongolia, Pakistan, Russia, Turkmenistan, Turkey, Ukraine, Uzbekistan.

Ургах орчин

Хужир марз, марзлаг элс, голын хөндий, хотгор хотос, бургас улиасан шугуй.

Habitat: Saline sand, saline soils along rivers.

Статус

Дэлхийн байгаль хамгаалах холбооны улаан данс - **Эмзэг**

Монголд зөвхөн Их нууруудын хотгор, Зүүнгарын говийн тойрогт ургана.

Conservation status: IUCN Red list Globally and Regionally - **Vulnerable (VU)**

This species grows only in Depression of Great Lakes and Dzungarian Gobi regions of Mongolia.

БАЙТАГ САРНАЙ (Wild Rosa)



Таних шинж

Сөөг, 1-2 м өндөр. Навч 3-8 энгийн навчтай. Өргөс нарийн шулуун. Дэлбээ 5, цагаан, өндөгөрхүү өргөн, сууриасаа эргэсэн, үзүүр мохоо. Жимс улаан, бөөрөрхүү. 6, 7 дугаар сард цэцэглэж, 8, 9 дүгээр сард үрлэнэ.

Rosa baitagensis
Kamelin & Gubanov
(Байтаг сарнай), 1988

Ангилал зүй / Тахонуу

Хүрээ: / Phylum: Tracheophyta

Анги: / Class: Magnoliopsida

Баг: / Order: Rosales

Овог: Сарнай / Family: Rosaceae

Төрөл: Сарнай / Genus: Rosa

Description: Shrubs 1–2 m tall. Leaves including petiole 3–8 cm. Prickles scattered, straight. Petals 5, white, broadly obovate, base broadly cuneate, apex emarginate. Hip red, pyriform or ellipsoid. Flowering June to July, and fruiting August to September.

Ерөнхий тархалт Монгол (Байтаг Богд уул)

Ургах орчин

Голын хад чулуутай эргээр


Энэ зүйл нь зөвхөн ГИДЦГ-ын “Б” хэсгийн Байтаг Богд ууланд ургадаг.

Бэлчээр, тэжээлийн чухал ургамал

General distribution: Mongolia (Baitag Bogd Mt)

Habitat: Rocky and stony of riverside

This species grows only in the Baitag Bogd Mountain of GGB SPA



БОТГОН ТАВАГ, ЗЭЭРИЙН УНД

Botgon tavag, Zeeriin und



*Zygophyllum
rosowii*

Bunge (Розовын хотир), 1843

Ангилал зүй / Тахonomy

Хүрээ: / Phylum: Tracheophyta

Анги: / Class: Magnoliopsida

Баг: / Order: Zygophyllales

Овог: Хотир / Family: Zygophyllaceae

Төрөл: Хотир / Genus: *Zygophyllum*

Таних шинж

Олон наст өвслөг ургамал, 10-20 см өндөр. Үндэс 3 см бүдүүн. Иш нь ацан салаалсан, гөлгөр, горвитой. Дагавар навч тодорхой, өндгөрхүү, 2-3 мм, цагаан хальслаг. Нэг хос навчинцартай, навчны илтэс өндгөрхүү, дугуй эсвэл гонзгой, хэлтгий талтай. Цэцэг навчны өвөрт 1 юмуу 2-оороо байрладаг.

Description: Herbs, perennial, 10-20 cm tall. Roots to 3 cm thick, woody. Stems much branched, glabrous, with ribs. Stipules distinct, ovate, 2-3 mm, white membranous. Leaves with 2 leaflets; leaflet blades ovate, rotund, or oblong. Flowers axillary, solitary or paired. Sepals elliptic to obovate-oblong, 5-8 × 2-3 mm, margin membranous. Petals 5, white but orange at base, obovate. Capsule linear-lanceolate, slightly curved or falcate, apex acuminate. Seeds grayish blue, oblong-ovoid. Flowering and fruiting time June to July.

Цоморлигийн навчинцар 5–8 мм урт, 1-5 мм өргөн, зууван, ухаараа цагаан хальслаг. Дэлбээн хэлтэс 5, тонгоруу өндгөрхүү, үзүүр дүгрэг, цагаавтар, сууриндаа шаргалдуу. Хонхорцог шугаман юлдэрхүү, үл ялиг эргэсэн эсвэл хадуураархуу муруй. Үр цэнхэр сааралдуу, гонзгой өндгөрхүү. 6, 7 дугаар сард цэцэглэж, үрлэнэ.

Ерөнхий тархалт Хятад, Казахстан, Киргиз, Монгол, Тажикистан

General distribution: China, Kazakhstan, Kyrgyzstan, Mongolia, Tajikistan

Ургах орчин

Үйрмэг чулуут цөл, уул толгодын бэл хормой, чулуурхаг хажуу, хад асга, улаан шавар, булгийн марзлаг эрэг.

Эмийн ургамал

Habitat: Gravel hills, alluvial gravel slopes, rocky steep slopes, rocky areas with gravel and sand

Medicinal plant.

ТААР

Taar



Таних шинж

Зэвгэр ногоон, 3-10 см өндөр, нягт, дэрэрхүү дэгнүүл үүсгэдэг намхан заримдаг сөөг. Иш мушгирсан. Навч богинохон, 1.5-5 мм урт, зэвгэр ногоон, цувраа, хурц өргөслөг, тэвнэрхүү, сууриараа өргөссөн, тэр хэсэгтээ хальсархаг эмжээртэй, ишээ далдалж нягт байрласан, навчны өвөрт багц

*Nanophyton
erinaceum* (Pall.)
Bunge (Зараархуу таар), 1862

Ангилал зүй /Taxonomy

Хүрээ: / Phylum: Tracheophyta

Анги: / Class: Magnoliopsida

Баг: / Order: Caryophyllales

Овог: Гагадайтан / Family: Amaranthaceae

Төрөл: Таар / Genus: *Nanophyton*

Description: Subshrub, cushion shaped, glaucous-green, 3-10 cm tall. Stem twisted. Leaves 1.5-5 mm, abaxially papillate; leaf axil cottony. Bracts and bractlets similar, proximal margin membranous. Perianth segments sublustrous, white-yellow, veinless, 8-12 mm in fruit. Flowering and fruiting time July to September.

үслэгтэй. Цэцгийн шадар эрхтэн цагаан шаргал, жимслэх үест хөөж томрон өндгөрхүү түнтийж, 8-12 мм болдог. 7-9 дүгээр сард цэцэглэж, үрлэнэ.

Ерөнхий тархалт

Хятад, Монгол, Орос, Төв Ази

General distribution: China, Mongolia, Russia, Central Asia

Ургах орчин

Говь цөл, чулуурхаг хажуу

Habitat: Gobi Desert, rocky slopes

Бэлчээр, тэжээлийн чухал ургамал

Important forage plant for livestock

ДАВССАГ ЗАГ

Davssag zag (Saxaul)



Таних шинж

Жижиг мод, 1-3 м өндөр. Гол иш бүдүүн, 50 см голчтой, салаалсан, холтос цагаан юмуу цайвар, титмийн орой, захаар байрлах ногоон, саарал ногоон нэг наст мөчир урт, нарийхан. Иш мөчир нь үетэй, навчгүй юм уу найлзуурын үеийн ирмэгээр маш богинохон төвгөр үлдвэртэй. Цэцэглэх

*Haloxylon
ammодendron* (C.A. Mey.)
Bunge (Цагаан модот заг), 1851

Ангилал зүй /Taxonomy

Хүрээ: / Phylum: Tracheophyta

Анги: / Class: Magnoliopsida

Баг: / Order: Caryophyllales

Овог: Гагадайтан / Family: Amaranthaceae

Төрөл: Заг / Genus: *Haloxylon*

Description: Trees small, 1-3 m tall. Trunk to 50 cm in diam. at ground level; bark gray-white; older branches gray-brown or light yellow-brown. Leaves completely absent or in form of very short projections at margins of shoot segments. Flowers borne on dwarf, lateral spurs of previous year's branches; bractlets navicular, broadly ovate, nearly equaling perianth, margin membranous. Seed black. Flowering and fruiting time May to October.

мөчир нь өнгөрсөн жилийн найлзуур дээр гардаг. Цэцэг мөчрийн доод үен дээр ганцаар юмуу хосолж чагтлан байрладаг. Цэцгийн шадар эрхтэн 5 саланги хальсан навчинцартай. Жимслэх үед өргөн далбан үүсгэдэг. Үр хар, 5-10 сард цэцэглэж үрлэнэ.

Ерөнхий тархалт

Хятад, Монгол, Төв Ази

General distribution: China, Mongolia, Central Asia

Ургах орчин

Манхан элс, хужир марзат цөл, голын хөвөө орчмын элсэрхэг газар.

Говьд олон зүйлийн амьтан, ургамлын амьдрах орчин болдог төдийгүй элсний нүүдэл, хөрсний элэгдлээс хамгаалахад чухал үүрэгтэй.

Habitat: Dunes, saline-alkaline desert, sandy places on riversides

Species important for the prevention of sand movement and soil erosion, also as protective habitat for animals and other plants of the Gobi.